

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.ДЭЛГЭРСАЙХАНЫ  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-/ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит болон ээлжит бус дараах хурлуудад цахимаар оролцох болон тогтоолын төсөлд бичгээр саналаа өгөх хэлбэрээр холбогдох шийдвэр гаргахад саналаа өгч ажилласан.

- 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлууд дараах хугацаанд хуралдав.**
  - 1.1. 2023.01.05-ны өдөр;
  - 1.2. 2023.02.02-ны өдөр;
  - 1.3. 2023.02.09-ний өдөр;
  - 1.4. 2023.02.17-ны өдөр;
  - 1.5. 2023.02.28-ны өдөр;
  - 1.6. 2023.03.15-ны өдөр;
  - 1.7. 2023.03.17-ны өдөр;
  - 1.8. 2023.03.21-ний өдөр;
  - 1.9. 2023.03.27-ны өдөр;
  - 1.10. 2023.04.04-ний өдөр;
  - 1.11. 2023.04.13-ны өдөр;
  - 1.12. 2023.04.25-ны өдөр;
  - 1.13. 2023.04.27-ны өдөр;
  - 1.14. 2023.05.26-ны өдөр;
  - 1.15. 2023.06.06-ны өдөр;
  - 1.16. 2023.06.22-ны өдөр;
- 2. Аудитын хорооны хурал дараах хугацаанд хуралдав.**
  - 2.1. 2023.02.16-ны өдөр.
  - 2.2. 2023.05.03-ны өдөр
- 3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал хуралсан байдал.**
  - 3.1. 2023.02.06-ны өдөр;
  - 3.2. 2023.04.18-ны өдөр;
  - 3.3. 2023.06.05-ны өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуутай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. ХХБ-аас 2023 онд баримтлах Эрсдэлийн аппетитыг батлах;
2. Банкны хөрөнгө оруулалттай компанийн ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлуудад оролцох, шийдвэр гаргах, холбогдох бичиг баримтанд гарын үсэг зурах эрх олгох;
3. ДАГ-ын 2022 оны ажлын тайланг хэлэлцэх;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах, үнэлгээ дүгнэлт гаргах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ХХБ-ны засаглалтай холбоотой бодлого, журмуудыг батлах;
7. ХЭ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8. Банкны тогтворжуулах төлөвлөгөөг батлах;
9. ХББ-ны 2022 оны аудитлагдсан тайланг хүлээн авах;
10. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
11. ХХБ-ны нийтэд санал болгох хувьцааны үнийг тогтоох
12. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;
13. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
14. ХХБ-ны 2023 оны Чанаргүй зээлийг бууруулах стратегийн 1-р улирлын гүйцэтгэл зэрэг асуудлууд болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу тайлантухагацаанд банкны холбогдот этгээдтэй хийх 4 хэлцэлд зөвшөөрөл өгөх тухай шийдвэр гаргалтанд саналаа өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энххүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан.

Тайлант хугацаанд хуралд оролцоходо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- *Банк IPO хийхтэй холбоотой хувьцаа үнэлгээ, үнэтэй холбоотой асуулт асууж, зөвлөмж өгсөн;*
- *Банкны эрсдлийн удирдлагын бодлогын хэрэгжсилт, өөрчлөлт тэдгээрийн шалтгаан цаашид хэрэгжсилтийг сайжруулах;*
- *Эрсдлийн хүлиэх түвшин түүний өөрчлөлт, шалтгаан,*
- *ДАГ-н үйл ажиллагааны үр дүн, тайлагналыг сайжруулах, хүний нөөцийн сургалт, хүрэлцээний хүрээнд санал дүгнэлт, зөвлөмж;*
- *Шинэ хөрөнгө оруулалтын үр ашиг, хэрэгжсилт, төсвийн саналыг хэрхэн бэлтгэсэн талаар асуулт тодруулга авлаа.*
- *Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрэгжүүлэх, үндсэн шаардлага, шалтгаан, эрх зүйн үндэслэл, банкыг алдагдалт оруулах нөхцөл үүсэх талаар асуулт, тодруулга авлаа.*

Тухайн хугацаанд банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан, ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгавар, тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээлэлтэй танилцах зэрэг ажлуудыг хурлын бус байдлаар хийлээ. Мөн Монголбанктай хийсэн уулзалтын хүрээнд МБ-н засаглалын журам зэргийг ТУЗ-н ажлын албанаас ирүүлсэнтэй танилцаа.

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрэм, Ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа,

гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТҮЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-/ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гишүүн, даргаар өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, ЦУНДХ-ны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд санаалаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараах хугацаанд хуралдav.**

- 1.1. 2023.02.02 ба 3-ны өдөр;
- 1.2. 2023.02.09-ний өдөр;
- 1.3. 2023.02.17-ны өдөр;
- 1.4. 2023.02.28-ны өдөр;
- 1.5. 2023.03.15-ны өдөр;
- 1.6. 2023.03.17-ны өдөр;
- 1.7. 2023.03.21-ний өдөр;
- 1.8. 2023.03.28-ны өдөр;
- 1.9. 2023.04.04-ний өдөр;
- 1.10. 2023.04.13-ны өдөр;
- 1.11. 2023.04.25-ны өдөр;
- 1.12. 2023.04.27-ны өдөр;
- 1.13. 2023.05.16-ны өдөр;
- 1.14. 2023.05.26-ны өдөр;
- 1.15. 2023.06.22-ны өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
2. ХХБ-ны 2023 оны Эрсдэлийн аппетитыг хэлэлцэн батлах;
3. Банкны засаглалтай холбоотой бодлого, журам, зааврыг хэлэлцэн батлах;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах, үнэлгээ дүгнэлт гаргах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. ДАГ-ын 2022 оны ажлын тайланг хэлэлцэх;
7. Банкны 2022 оны аудитлагдсан тайланг хүлээн авах;
8. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлийг шийдвэрлэх;
9. IPO гаргахтай холбоотой банкны бизнесийн үнэлгээтэй танилцах, нийтэд санал болгох хувьцааны үнийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;
10. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;

11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
12. Ногдол ашиг хуваарилах;
13. Банкны оруулсан хөрөнгө оруулалтын үр дүн, өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцах;
14. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХороо нь нийт 4 удаа хуралдаж, ДАГ болон түүний харьяа хэлтэс, ТУЗДАА-ны ажилтнуудын 2023 онд мөрдөх бүтгээмжийн цалинг хэлэлцэж шийдвэрлэх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн дэргэдэх Хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан.

Тайлант хугацаанд буюу 2023 оны эхний хагас жилд нийт 2 сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудалд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан.

2023 оны эхний хагас жилд Банк нь нээлттэй компани болох, олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгохтой холбоотойгоор ТУЗ, түүний дэргэдэх Ажлын алба, Банкны удирдлагын баг нэлээд ачаалалтай ажилласны үр дүнд хуулийн хугацаанд ХК болох зорилтоо амжилттай биелүүлж чадлаа.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжээс хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК  
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН З.НАРАНТУЯАГИЙН  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ-/ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар тус тус ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурал Эрсдэлийн удирдлагын хорооны дараах хурлуудад оролцож, холбогдох шийдвэрүүд гаргахад саналаа өгч ажилласан.

**1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлууд**

- 1.1. 2023.03.15-ны өдөр;
- 1.2. 2023.03.17-ны өдөр;
- 1.3. 2023.03.21-ний өдөр;
- 1.4. 2023.03.28-ны өдөр;
- 1.5. 2023.04.04-ний өдөр;
- 1.6. 2023.04.13-ны өдөр;
- 1.7. 2023.04.25-ны өдөр;
- 1.8. 2023.04.27-ны өдөр;
- 1.9. 2023.05.26-ны өдөр;
- 1.10. 2023.06.06-ны өдөр;
- 1.11. 2023.06.22-ны өдөр;

**2. Эрсдэлийн удирдлагын хорооны хурал**

- 2.1. 2023.03.31-ний өдөр;
- 2.2. 2023.04.18-ны өдөр;
- 2.3. 2023.06.05-ны өдөр.

Энэхүү хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд: ТУЗ-ийн хурлаар

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
2. Банкны 2022 оны аудитлагдсан тайланг хүлээн авах;
3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлтийг шийдвэрлэх;
4. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах, үнэлгээ дүгнэлт гаргах;
5. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
6. IPO гаргахтай холбоотой банкны бизнесийн үнэлгээтэй танилцах, нийтэд санал болгох хувьцааны үнийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;
7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;
8. Ногдол ашгийн хэмжээ хуваарилах асуудлыг шийдвэрлэх;
9. ХХБ-ны Тогтвортжуулах төлөвлөгөө 2023-г батлах, шинэчлэн батлах;

10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ХХБ-ны журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
11. Банкны оруулсан хөрөнгө оруулалтын үр дүн, өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцах;
12. Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэрлэх бусад асуудлуудыг хэлэлцэн зохих шийдвэрийг гаргасан бол ЭУХорооны хурлаар ХХБ-ны 2023 оны Тогтвортжуулах төлөвлөгөө, Чанаргүй зээлийг бууруулах стратегийн 1-р улирлын гүйцэтгэл зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэрүүд байсан гэж үзэж байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд өөрийн саналаа тусгаж ажилласан.

Тайлант хугацаанд 4 удаа сонирхлын зөрчилтэй хэлцэлд санал өгсөн бөгөөд зарчмын зөрүүтэй санал байгаагүй, энэхүү шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн шийдвэр байсан.

Тайлант хугацаанд ТҮЗөвлөл, түүний дэргэдэх ажлын алба болон банкны удирдлагын багийн зүгээс 2023 онд тавьсан стратегийн зорилго, зорилтоо биеллүүлэхийн төлөө чармайн ажилласны зэрэгцээ нээлттэй компани болох бэлтгэл ажлыг хугацаанд нь гүйцэтгэж, хувьцаагаа анх удаа биржэд амжилттай гаргалаа.

Банк болон ТҮЗДАА-ны зүгээс гишүүний чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангахад анхаарч ирсэн ба миний хувьд өнгөрсөн хугацаанд ТҮЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.